

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2023/112/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2023 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор Ц.Төмөрсүх

Утас: 9805-8805, Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Дорнод аймгийн Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.24 № 259

танай _____-ны № _____-т

Г ДАШБАЛБАР СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020356

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Дорнод аймгийн Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>250,371,689.15</u>	<u>117,512,995.19</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,253,714.96	6,340,570.72
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,253,714.96	6,340,570.72
3121	Төгрөг	1,253,714.96	6,340,570.72
31211	Төрийн сангийн харилцах	1,253,714.96	6,340,570.72
33	АВЛАГА	135,243,900.00	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	135,243,900.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	113,874,074.19	111,172,424.47
351	Түүхий эд материал	32,985,119.79	23,290,761.95
35130	Эм боох материал	32,985,119.79	23,290,761.95
354	Хангамжийн материал	33,128,954.40	34,991,662.52
35410	Бичиг хэргийн материал	818,450.00	541,550.00
35420	Аж ахуйн материал	30,676,704.40	34,450,112.52
35440	Түлш, шатах тослох материал	1,633,800.00	-
35600	Мал амьтад	47,760,000.00	52,890,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,206,467,627.02</u>	<u>1,216,466,852.16</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,206,467,627.02	1,216,466,852.16
392	Биет хөрөнгө	1,188,043,627.02	1,198,042,852.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,064,076,587.58	1,064,076,587.58
39202	Хуримтлагдсан элэгдэл	(71,323,600.31)	(103,766,829.72)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	74,810,165.00	74,810,165.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(28,310,164.98)	(38,643,498.30)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	236,857,571.62	323,342,786.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(141,932,889.86)	(167,184,407.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,354,391.50	51,969,391.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,235,577.01)	(26,263,661.43)
39209	Зам, гүүрийн байгууламж	4,537,400.00	4,537,400.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(545,376.78)	(975,576.78)
39214	Бусад үндсэн хөрөнгө	57,751,133.00	57,751,133.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(36,996,012.74)	(41,610,638.30)
393	Биет бус хөрөнгө	18,424,000.00	18,424,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	18,424,000.00	18,424,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,456,839,316.17</u>	<u>1,333,979,847.35</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>0.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,456,839,316.17</u>	<u>1,333,979,847.35</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,456,839,316.17	1,333,979,847.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	451,870,146.75	451,870,146.75
51101	Өмч: - төрийн	451,870,146.75	451,870,146.75
512	Хуримтлагдсан үр дүн	754,114,009.76	631,254,540.94
51210	Өмнөх үеийн үр дүн	488,758,232.68	754,114,009.76
51220	Тайлант үеийн үр дүн	265,355,777.08	(122,859,468.82)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	250,855,159.66	250,855,159.66
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,456,839,316.17</u>	<u>1,333,979,847.35</u>

**Дорнод аймгийн Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/Төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,370,850,963.71	724,315,419.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	363,636,055.71	108,394,869.83
120	Нийтлэг татварын бус орлого	363,586,055.71	108,394,869.83
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,609,000.00	14,145,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,865,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	23,609,000.00	6,280,000.00
120009	Бусад орлого	-	7,190,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө	111,915,483.56	30,783,160.31
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал	228,061,572.15	56,276,709.52
122	Тусламжийн орлого	50,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	50,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,007,214,908.00	615,920,550.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	597,496,900.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	597,496,900.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	371,213,400.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,096,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	204,906,100.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,967,400.00	-
131107	Төсвийн урамшуулал	135,243,900.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,145,800.00	31,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,145,800.00	31,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	12,358,808.00	584,920,550.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,358,808.00	584,920,550.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,103,015,186.63	846,434,888.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,103,015,186.63	846,434,888.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,052,437,249.91	784,434,701.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	454,773,779.00	433,454,699.69
210101	Үндсэн цалин	263,830,740.00	294,598,942.14
210102	Нэмэгдэл	144,413,543.00	89,832,249.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,075,000.00	7,243,000.00
210104	Урамшуулал	39,454,496.00	32,484,883.85
210105	Гэрээт ажлын хөлс	-	9,295,624.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,324,726.35	54,415,338.12
210201	Тэтгэврийн даатгал	43,231,467.64	38,265,412.54
210202	Тэтгэмжийн даатгал	4,630,267.17	4,336,645.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,569,813.74	3,405,476.44
210204	Ажилгүйдлийн даатгал	808,470.70	764,345.69
210205	Эрүүл мэндийн даатгал	8,084,707.10	7,643,457.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,019,493.28	27,633,612.67
210301	Гэрэл, цахилгаан	8,524,871.28	8,801,606.37

**Дорнод аймгийн Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210302	Түлш, халаалт	14,074,622.00	17,032,006.30
210303	Цэвэр, бохир ус	1,420,000.00	1,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,512,270.00	31,255,566.00
210401	Бичиг хэрэг	2,806,650.00	3,968,990.00
210402	Тээвэр, шатахуун	13,956,695.00	15,386,714.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,250,010.00	1,389,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,233,450.00	1,197,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,634,180.00	5,767,350.00
210408	Бараа материал акталсны зардал	9,631,285.00	3,546,162.00
2105	Нормативт зардал	389,379,098.68	136,548,729.67
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	376,616,848.68	126,176,929.67
210502	Хоол, хүнс	12,342,250.00	10,371,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	420,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,120,930.00	7,154,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,010,300.00	-
210604	Урсгал засвар	5,110,630.00	7,154,500.00
2107	Томилолт, зочны зардал	4,076,000.00	2,743,000.00
210702	Дотоод албан томилолт	4,076,000.00	2,743,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,637,926.00	656,560.00
210803	Даатгалын үйлчилгээ	996,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	63,144.00	123,560.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	470,000.00	445,000.00
210807	Газрын төлбөр	20,782.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77,593,026.60	90,572,695.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,592,950.00	10,425,790.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,000,076.60	80,146,905.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,577,936.72	62,000,187.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,400,000.00	62,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	43,400,000.00	62,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,177,936.72	187.33
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,177,936.72	187.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	267,835,777.08	(122,119,468.82)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,480,000.00	740,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,480,000.00	740,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,480,000.00)	(740,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	265,355,777.08	(122,859,468.82)

Дорнод аймгийн Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	877,971,008.00	827,294,064.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,000,000.00	76,129,614.96
120	Нийтлэг татварын бус орлого	6,000,000.00	76,129,614.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,000,000.00	74,929,614.96
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000,000.00	14,265,000.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	60,664,614.96
120009	Бусад орлого	-	1,200,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	871,971,008.00	751,164,450.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	597,496,900.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	597,496,900.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	235,969,500.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,096,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	204,906,100.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,967,400.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,145,800.00	31,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,145,800.00	31,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	12,358,808.00	720,164,450.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,358,808.00	720,164,450.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	841,883,293.04	762,844,239.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	841,883,293.04	762,844,239.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	791,305,356.32	640,179,436.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	454,773,779.00	433,454,699.69
210101	Үндсэн цалин	263,830,740.00	294,598,942.14
210102	Нэмэгдэл	144,413,543.00	89,832,249.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,075,000.00	7,243,000.00
210104	Урамшуулал	39,454,496.00	32,484,883.85
210105	Гэрээт ажлын хөлс	-	9,295,624.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,324,726.35	54,415,338.12
210201	Тэтгэврийн даатгал	43,231,467.64	38,265,412.54
210202	Тэтгэмжийн даатгал	4,630,267.17	4,336,645.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,569,813.74	3,405,476.44
210204	Ажилгүйдлийн даатгал	808,470.70	764,345.69
210205	Эрүүл мэндийн даатгал	8,084,707.10	7,643,457.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,467,913.28	25,999,812.67
210301	Гэрэл, цахилгаан	8,524,871.28	8,801,606.37
210302	Түлш, халаалт	13,523,042.00	15,398,206.30
210303	Цэвэр, бохир ус	1,420,000.00	1,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,052,885.00	28,992,104.00
210401	Бичиг хэрэг	2,901,400.00	3,348,690.00
210402	Тээвэр, шатахуун	13,956,695.00	15,386,714.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,327,010.00	1,389,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,998,680.00	2,406,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,869,100.00	6,461,200.00

Дорнод аймгийн Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	202,112,546.69	74,222,272.43
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	186,592,546.69	61,107,472.43
210502	Хоол, хүнс	10,739,500.00	10,371,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,780,500.00	2,743,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,545,730.00	8,895,960.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,547,700.00	1,828,060.00
210604	Урсгал засвар	4,998,030.00	7,067,900.00
2107	Томилолт, зочны зардал	4,076,000.00	2,743,000.00
210702	Дотоод албан томилолт	4,076,000.00	2,743,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,637,926.00	656,560.00
210803	Даатгалын үйлчилгээ	996,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	63,144.00	123,560.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	470,000.00	445,000.00
210807	Газрын төлбөр	20,782.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,313,850.00	10,799,690.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,313,850.00	10,799,690.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,577,936.72	122,664,802.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,400,000.00	62,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	43,400,000.00	62,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,177,936.72	60,664,802.29
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,177,936.72	60,664,802.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	36,087,714.96	64,449,825.76
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	34,834,000.00	59,362,970.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	34,834,000.00	59,362,970.00
2200	Дотоод эх үүсвэрээр	34,834,000.00	59,362,970.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	34,834,000.00	59,362,970.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(34,834,000.00)	(59,362,970.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,253,714.96	5,086,855.76
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,253,714.96
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,253,714.96	6,340,570.72

Дорнод аймгийн Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	451,870,146.75	253,918,319.24	488,758,232.68	1,194,546,698.67
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	451,870,146.75	253,918,319.24	488,758,232.68	1,194,546,698.67
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(3,063,159.58)	-	(3,063,159.58)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	265,355,777.08	265,355,777.08
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	451,870,146.75	250,855,159.66	754,114,009.76	1,456,839,316.17
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	451,870,146.75	250,855,159.66	754,114,009.76	1,456,839,316.17
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	451,870,146.75	250,855,159.66	754,114,009.76	1,456,839,316.17
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(122,859,468.82)	(122,859,468.82)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	451,870,146.75	250,855,159.66	631,254,540.94	1,333,979,847.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	842,304,900.00	679,204,406.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	842,304,900.00	679,204,406.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	842,304,900.00	679,204,406.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	498,478,500.00	433,454,699.69
210101	Үндсэн цалин	297,134,100.00	294,598,942.14
210102	Нэмэгдэл	122,638,900.00	89,832,249.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,005,900.00	7,243,000.00
210104	Урамшуулал	59,779,600.00	32,484,883.85
210105	Гэрээт ажлын хөлс	10,920,000.00	9,295,624.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,304,300.00	54,415,338.12
210201	Тэтгэврийн даатгал	44,658,000.00	38,265,412.54
210202	Тэтгэмжийн даатгал	4,911,600.00	4,336,645.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,929,300.00	3,405,476.44
210204	Ажилгүйдлийн даатгал	982,300.00	764,345.69
210205	Эрүүл мэндийн даатгал	9,823,100.00	7,643,457.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,000,000.00	25,999,812.67
210301	Гэрэл, цахилгаан	9,700,000.00	8,801,606.37
210302	Түлш, халаалт	14,500,000.00	15,398,206.30
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	71,543,600.00	28,992,104.00
210401	Бичиг хэрэг	5,426,800.00	3,348,690.00
210402	Тээвэр, шатахуун	22,831,600.00	15,386,714.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,160,700.00	1,389,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,011,200.00	2,406,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	38,113,300.00	6,461,200.00
2105	Нормативт зардал	90,398,000.00	74,222,272.43
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	71,501,400.00	61,107,472.43
210502	Хоол, хүнс	13,621,600.00	10,371,800.00

**Дорнод аймгийн Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,275,000.00	2,743,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	61,028,700.00	53,710,940.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	51,153,700.00	46,643,040.00
210604	Урсгал засвар	9,875,000.00	7,067,900.00
2107	Томилолт, зочны зардал	5,420,000.00	2,743,000.00
210702	Дотоод албан томилолт	5,420,000.00	2,743,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,977,900.00	656,560.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,500,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,672,900.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350,000.00	123,560.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,335,000.00	445,000.00
210807	Газрын төлбөр	20,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,153,900.00	5,009,680.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,153,900.00	5,009,680.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	842,304,900.00	685,544,977.63
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	31,000,000.00	30,999,812.67
122005	Орон нутгийн төсвөөс	31,000,000.00	30,999,812.67
12000	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	68,624,200.00	66,268,910.72
120010	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	68,624,200.00	66,268,910.72
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	742,680,700.00	588,276,254.24
122001	Хандив тусламж /дотоод/	742,680,700.00	588,276,254.24
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,253,714.96
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6,340,570.72

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/ төгрөгөөр /
Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	135,240,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	135,240,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,938,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,938,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,938,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121,302,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	62,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	59,302,900.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	59,302,900.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	135,240,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	135,240,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	135,135,900.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорнод аймгийн Дашбалбар сумын Эрүүл мэндийн төв нь эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг ард иргэдэд жигд хүртээмжтэй хүргэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хүн амын амьдралын хэв маягийг өөрчлөх, зөв дадал зуршилд сургахад чиглэгдэнэ.

Зорилго: Тус сум дундын эмнэлэг нь хүн амын эрүүл мэндийн хэрэгцээг хангасан нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг сумын болон харъя сумын хүн амд ээлтэй тэгш хүргэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ард иргэдэд хүргэн үйлчилж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Улсын төсвөөс санхүүждэг байсан бол тайлант онд эрүүл мэндийн даатгалын сангаас бүрэн санхүүждэг, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймгийн Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дорнод аймгийн Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Дорнод аймгийн Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 122.8 сая төгрөгөөр буюу 8.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,253.7	6,340.6	5,086.9
Авлага	135,243.9	-	(135,243.9)
Бараа материал	113,874.1	111,172.4	(2,701.6)
Үндсэн хөрөнгө	1,206,467.6	1,216,466.9	9,999.2
Нийт хөрөнгө	1,456,839.3	1,333,979.8	(122,859.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,456,839.3	1,333,979.8	(122,859.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,456,839.3	1,333,979.8	(122,859.5)

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны авлага бүрэн төлөгдсөнтэй холбоотой байна. Авлага нь 2021 онд үзүүлсэн ковид-19 ийн эмчилгээний төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас авлага үүсгэн 2022 онд авлага бүрэн барагдаж 2022 онд шинээр авлага үүсээгүй байна.

Тайлант онд өссөн дүнгээр нийт 126.7 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал 56.2 сая, малын нас дэвшүүлсэн 19.2 сая, шинээр төл мал 6.2 сая төгрөгөөр тайланд тусгасан байна. Эмнэлгийн хэвийн үйл ажиллагааг хангах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд 193.7 төгрөгийн бараа материал зарцуулж, 3.5 сая төгрөгийн бараа материал акталж, 13.2 сая төгрөгийн малыг нас дэвшүүлэхээр зарлагдсан бол 0.7 сая төгрөгийн мал хорогдсон байна.

Үндсэн хөрөнгө данс 9.9 сая төгрөгөөр өссөн нь 90.1 сая төгрөгийн хөрөнгө орлогод бүртгэж, ИТХ-ын 2022 оны 10-р сарын 5 өдрийн 02 тоот тогтоолоор 3.0 сая төгрөгийн хөрөнгө акталж, 80.1 сая төгрөгийн элэгдэл тооцоолж байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 1,333.9 сая төгрөг болж 122.8 сая төгрөгөөр буурсан нь тайланд хугацааны алдагдалтай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 742.7 сая, оны эхний үлдэгдлээс 1.2 сая, орон нутгийн төсвөөс 31 сая, нийт зарлагыг 774,9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төлөвлөлтийг эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын дагуу аргачлалаар нэг иргэнээр тооцсон тогтмол санхүүжилт, гүйцэтгэлээр санхүүжих санхүүжилт гэж 2 ангиллаар төлөвлөсөн бөгөөд орох боломжтой санхүүжилтийн эх үүсвэрийг тооцоолж зардлыг төсөвлөсөн.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалаас 720.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсвөөс 31.0 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 7.9 сая төгрөг, бусад орлого 1.2 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 6.4 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 679.2 сая төгрөг буюу 81 хувьтай байгаа нь гүйцэтгэлийн санхүүжилтийг төсөвлөсөн хэмжээнд аваагүй, нэг иргэнээр санхүүжих санхүүжилт 13.1 сая төгрөгөөр дутуу авсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 135.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан бөгөөд үүнээс 59.3 сая төгрөгийг үндсэн дансанд төвлөрүүлж 75.9 сая төгрөгийн зарцуулалт хийсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Ахмадын сувилал	2022.06.02 – 2022.08.15	80 ахмад настанд үйлчилгээ үзүүлэх	100%	2,500.0	2,500.0
2	Хүүхдийн сувилал	2022.06.01 – 2022.08.30	30 хүүхдэд үйлчилгээ үзүүлэх	100%	600.0	600.0
3	Ковидын сэргээн засах сувилал	2022.06.15 – 2022.08.30	110 иргэнд үйлчилгээ үзүүлэх	100%	3,300.0	3,300.0
4	Нэмэлт дархлаажуулалт	2022.05.01 – 2022.05.30	5 багийн 300 иргэнд ковид-19-ийн нэмэлт дархлаажуулалт хийх.	100%	640.0	640.0

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймгийн Дашбалбар сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Нурболат, аудитор Ц.Төмөрсүх, хяналтыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 2 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 846.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 12.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор санхүүгийн сахилга батыг мөрдөж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлан ажилласан байна.

Тухайн байгууллагын батлагдсан орон тоон дээр дэд дарга, орлогчийн албан тушаалын ажилтан байхгүй байгаа бөгөөд авто тээврийн хэрэгсэл нь эмнэлгийн тусламж үйлчилгээ буюу төрийн хэмнэлтийн хуулийн 6 дугаар зүйлд заасан авто тээврийн хэрэгсэл ашиглах хэрэгцээ, шаардлагатай байгууллага байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус байгууллага нь 2022 онд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 129.9 сая төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх онд түүвэрт хамрагдсан тул аудитаар ороогүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдах авах гэрээ, тайланг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуультай нийцэж байх эсэхийг үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6.4 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулсан. Үүнд: Туслах аж ахуй буюу байгууллагын эзэмшилд байсан мал амьтадыг худалдан борлуулж үүнээс олсон орлогыг байгууллагын кассад хүлээн авсан бөгөөд үүнийг үйл ажиллагаатай холбоотой гарсан худалдан авалтад зарцуулсан байна.

Аудитаар нийт 136.7 сая төгрөгийн зөрчил² илэрснийг 2 албан шаардлага, 1 төлбөрийн акт хүргүүлсэн.

5.1 Албан шаардлага

Тайлант онд Гантэлмэн байгууллагаас 360.0. мянган төгрөгийн худалдан авалтын нэмэгдсэн өртгийн албан татварын цахим төлбөрийн баримт гаргуулан аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, сангийн сайдын 2017 оны 347 тушаалаар батлагдсан өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэж заасныг зөрчсөн, хэрэгжүүлж ажиллаагүй байна.

5.2 Төлбөрийн акт

Тайлант онд Ковид-19-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд ажилласан ажилтнуудад нэг удаагийн тэтгэмж болох нийт 62.0 сая төгрөгийг олгохдоо хувь хүний орлогын албан татвар суутгаагүй. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна.”, 14 дүгээр зүйлийн 14,1-д “Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна.” 7 дугаар зүйлийн 7.1-д “Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна:”, 7.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт: Туслах аж ахуй буюу байгууллагын эзэмшилд байсан мал амьтадыг 6.4 сая төгрөгөөр худалдан борлуулж үүнээс олсон орлогыг байгууллагын кассад хүлээн авсан бөгөөд үүнийг үйл ажиллагаатай холбоотой гарсан худалдан авалтад зарцуулсан, кассын баримт үдэж цэгцлээгүй, туслах аж ахуй эрхлэх зөвшөөрөл, кассын нярав томилсон тушаал, касс тайлан гаргаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын хавсралт-1 “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Зөвлөмж: Байгууллагын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд бэлэн мөнгөөр гүйлгээ гаргахгүй байх, мөнгөн касс хөтлөх тохиолдолд байгууллагын даргын тушаал гаргуулан хариуцан ажиллах нярвыг томилон Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын хавсралт-1 “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дорнод аймгийн Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Туслах аж ахуй буюу байгууллагын эзэмшилд байсан мал амьтадыг худалдан борлуулж үүнээс олсон орлогыг байгууллагын кассад хүлээн авсан бөгөөд үүнийг үйл ажиллагаатай холбоотой гарсан худалдан авалтад зарцуулсан байна. Ингэхдээ Сангийн сайдын тушаалаар батлагдсан төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллаагүй /Кассын баримт үдэж цэгцлээгүй, Туслах аж ахуй эрхлэх зөвшөөрөл, кассын нярав томилсон тушаал, касс тайлан ирүүлээгүй/	1	6,400.0									1	6,400.0
Дүн	1	6,400.0									1	6,400.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн төлбөрт цахим төлбөрийн баримт шивүүлээгүй	1	360.0			1	360.0						
Тайлант онд Ковид-19-ын эрсдлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд ажилласан ажилтнуудад нэг удаагын тэтгэмж болох нийт 62.0 сая төгрөгийг олгохдоо хувь хүний орлогын албан татвар суутгаагүй	1	6,200.0	1	6,200.0								
Дүн	2	6,560.0	1	6,200.0	1	360.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
2022 онд шилэн дансны мэдээллийг байршуулахдаа орлогын дүнг мэдүүлээгүй /1сарын дүн/	1	129,993.7			1	129,993.7		
Дүн	1	129,993.7	0	-	1	129,993.7	0	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								